

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/14/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargal.ts@audit.mn

Аудитор: Б.Ариунжаргал
Утас: 262071 Цахим хаяг: ariunjargal.b@audit.mn

Си Эс Ай Аудит аудит ХХК-ийн захирал М.Сэвжидмаа
Утас: 70001981 Цахим хаяг: csi_sevjee@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/716
танай _____-ны № _____-т

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ М.МӨНХӨӨ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын 2023 оны нийт орлого өмнөх оноос 43,618.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь эрчим хүчний нэг Гкал-ын худалдах үнэ тариф 25,436.00 төгрөг буюу 53.3 хувиар, дулааны эрчим хүчний түгээлт 425.3 мянган Гкалаар өссөнтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Хувьцаа эзэмшигчийн хурлын 2023 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Амгалан дулааны станц ТӨХК-ийг 100.0 хувийн төрийн өмчит хаалттай хувьцаат компани болгож, нийт хувьцааны 66.0 хувийн төлөөллийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 34.0 хувийн төлөөллийг төрийн өмчийн асуудалд хариуцсан захиргааны байгууллага тус тус хэрэгжүүлнэ гэж дүрэмд өөрчлөлт оруулсан байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Эрчим хүчний сэргэлтийн зорилтын хүрээнд “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн 116 МВт хүчин чадалтай 65,689.8 сая төгрөгийн өртөгтэй нэг зуух нэмж барих төслийн барилга угсралтын ажлыг 2023 оны 4 дүгээр сард эхлүүлж, гүйцэтгэл 86.0 хувьтай байна.

Тус төслийн нийт өртгийг санхүүжүүлэхээр Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани болох Ди Би Эм Лизинг ХХК-аас 5 жилийн хугацаатай, SOFR 90 хоногийн хөвөгч хүүгийн нөхцөлтэй 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр СТГ-22/01 дугаартай санхүүгийн түрээсийн гэрээ байгуулж, 2023 онд нийт 42,740.8 сая төгрөгийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ авч, хүүгийн төлбөрт 842.7 сая төгрөгийг төлж, жилийн эцсийн байдлаар 29,176.7 сая төгрөгийн урт хугацаат өглөгтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 270 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	430,542,180.60	4,367,018,586.26
1.1.2	Дансны авлага	695,273,431.27	4,933,346,236.71
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	174,851,729.08	536,850,035.04
1.1.4	Бусад авлага	25,674,514.96	18,082,418.01
1.1.6	Бараа материал	1,481,011,481.63	2,810,084,061.54
1.1.7	Урьдчилж төлсөн зардал /тооцоо/	379,864,566.37	499,871,698.75
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,187,217,903.91	13,165,253,036.31
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	66,340,579,159.93	62,006,916,355.57
1.2.2	Биет бус хөрөнгө	13,074,698,860.80	13,055,842,556.79
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	549,088,865.68	625,880,046.13
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		54,964,854,361.45
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	79,964,366,886.41	130,653,493,319.94
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	83,151,584,790.32	143,818,746,356.25
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	5,572,005,146.19	13,764,603,856.55
2.1.1.2	Цалингийн өглөг	91,500.00	1,407,867.52
2.1.1.3	Татварын өр	733,606,070.93	3,386,986,747.37
2.1.1.4	НДШ-ийн өглөг	324,502,019.51	
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	106,188,472.12	84,370,494.12
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,736,393,208.75	17,237,368,965.56
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		29,176,704,889.97
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	2,008,501,506.90	2,394,864,048.78
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	799,541,361.34	713,280,779.20
2.1.2.5	Бусад хөрөнгө оруулалт		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,808,042,868.24	32,284,849,717.95
2.2	Өр төлбөрийн нийт дүн	9,544,436,076.99	49,522,218,683.51
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	99,598,987,346.37	99,598,987,346.37
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,497,013,552.23	2,559,125,684.08
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	13,005,849,600.00	13,005,849,600.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(41,494,701,785.27)	(20,867,434,957.71)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг		20,627,266,827.56
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	(41,494,701,785.27)	(41,494,701,785.27)
2.3.11	Эздийн өмчийн дүн	73,607,148,713.33	94,296,527,672.74
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	83,151,584,790.32	143,818,746,356.25

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	24,058,669,411.23	67,653,283,470.67
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	30,167,019,099.64	42,483,958,509.46
3	Нийт ашиг (алдагдал)	(6,108,349,688.41)	25,169,324,961.21
4	Түрээсийн орлого	2,503,800.00	3,960,000.00
5	Хүүний орлого		740,366.91
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	158,716,261.84	179,935,206.12
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,358,100,368.13	2,675,670,738.91
11	Санхүүгийн зардал	7,226,301.38	
12	Бусад зардал	246,770,608.10	289,637,068.45
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(8,559,226,904.18)	22,388,652,726.88
19	Орлогын татварын зардал	243,291,588.57	1,761,385,899.32
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(8,802,518,492.75)	20,627,266,827.56
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(8,802,518,492.75)	20,627,266,827.56
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(8,802,518,492.75)	20,627,266,827.56
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	99,598,987,346.37	2,496,116,697.19	13,005,849,600.00	(32,694,883,292.52)	82,406,070,351.04
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				2,700,000.00	2,700,000.00
Залруулсан үлдэгдэл	99,598,987,346.37	2,496,116,697.19	13,005,849,600.00	(32,694,883,292.52)	82,406,070,351.04
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(8,802,518,492.75)	(8,802,518,492.75)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		896,855.04			896,855.04
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	99,598,987,346.37	2,497,013,552.23	13,005,849,600.00	(41,494,701,785.27)	73,607,148,713.33
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	99,598,987,346.37	2,497,013,552.23	13,005,849,600.00	(41,494,701,785.27)	73,607,148,713.33
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				20,627,266,827.56	20,627,266,827.56
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		62,112,131.85			62,112,131.85
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	99,598,987,346.37	2,559,125,684.08	13,005,849,600.00	(20,867,434,957.71)	94,296,527,672.74

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1.0	Мөнгөн орлогын дүн (+)	26,751,286,889.00	70,328,940,625.76
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	26,518,670,498.98	70,181,548,562.29
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	24,066,264.00	22,709,729.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	208,550,126.02	124,682,334.47
1.2.0	Мөнгөн зарлагын дүн (-)	25,302,396,307.79	43,786,105,479.23
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,686,845,000.39	4,526,304,973.03
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	885,041,660.69	1,865,045,656.48
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	7,775,264,275.25	20,276,985,575.78
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,240,053,535.44	6,279,518,654.36
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,344,549,114.17	4,581,617,204.80
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	7,226,301.38	842,725,889.45
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	990,137,898.67	3,677,840,839.12
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	8,607,670.00	8,347,825.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,364,670,851.80	1,727,718,861.21
1.30	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,448,890,581.21	26,542,835,146.53
2.00	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(760,007,300.04)	(9,042,234,793.84)
2.10	Мөнгөн орлогын дүн (+)	-	740,366.91
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого		740,366.91
2.20	Мөнгөн зарлагын дүн (-)	760,007,300.04	9,042,975,160.75
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	760,007,300.04	9,042,975,160.75
2.30	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(760,007,300.04)	(9,042,234,793.84)
3.00	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.10	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.20	Мөнгөн зарлагын дүн (-)	333,333,333.34	13,564,123,947.03
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	333,333,333.34	
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		13,564,123,947.03
3.30	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(333,333,333.34)	(13,564,123,947.03)
4.00	Валютын ханшийн зөрүү	-	
4.10	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	355,549,947.83	3,936,476,405.66
5.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	74,992,232.77	430,542,180.60
6.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	430,542,180.60	4,367,018,586.26

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Өөрчлөлт /өссөн +/, /буурсан -/	
				Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Боловсруулсан ДЭХ	мян.Гкал	841.8	1,034.0	1,037.3	3.2	0.3
	Дотоод хэрэгцээний ДЭХ	мян.Гкал	14.0	14.5	13.0	(1.4)	(10.0)
	Дулаан түгээлт	мян.Гкал	827.8	1,019.6	1,024.2	4.7	0.5
2	Нийт орлого	мян.төг	24,219,889.5	67,734,959.2	67,837,919.0	102,959.8	0.2
	Үүнээс: Үйл ажиллагааны орлого	мян.төг	24,058,669.4	67,543,994.1	67,653,283.5	109,289.3	0.2
	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	161,220.1	190,965.1	184,635.6	(6,329.5)	(3.3)
3	Нийт зардал	мян.төг	32,779,116.4	48,582,049.3	45,449,266.3	(3,132,783.0)	(6.4)
	Үүнээс Удирдлагын зардал	мян.төг	138,166.8	95,993.6	87,345.8	(8,647.8)	(9.0)
4	Татварын өмнөх ашиг/алдагдал/	мян.төг	(8,559,226.9)	19,152,909.9	22,388,652.7	3,235,742.8	16.9
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	(8,802,518.5)	18,371,253.6	20,627,266.8	2,256,013.2	12.3
6	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг					
7	Нийт ажиллагсдын тоо	хүн	186.0	192.0	192.0		
8	Нийт цалингийн сан	сая.төг	4,442.0	5,614.6	5,584.6	(30.0)	(0.5)
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	төгрөг	1,990,163.5	2,436,878.0	2,423,871.5	(13,006.5)	(0.5)
10	Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ	төгрөг	39,596.1	47,649.3	44,373.6	(3,275.7)	(6.9)
11	Нэгж бүтээгдэхүүний өртөг ЦЭХ	төгрөг					
12	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал	төгрөг	1.35	0.72	0.67	(0.05)	(6.59)
13	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая.төг	1,228.6	2,683.8	2,522.6	(161.2)	(6.0)
14	Нийт авлага	сая.төг	895.9	800.0	5,488.3	4,688.3	586.0
	Үүнээс Найдваргүй	сая.төг					
15	Нийт өглөг	сая.төг	9,544.4	49,098.6	49,522.2	423.6	0.9
	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	6,736.4	23,535.6	17,237.4	(6,298.2)	(26.8)
	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	2,808.0	25,563.0	32,284.8	6,721.8	26.3
16	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	кг/Гкал	170.6	162.7	165.2	2.5	1.5

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 136.2 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
НӨАТ-ийн өглөгийн эхний үлдэгдлийг 123.4 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулахдаа тайлант оны гүйлгээгээр хүлээн зөвшөөрч бүртгэснээс НӨАТ-ийн ногдуулалт зөрүүтэй байна	1	123,350.2			1	123,350.2	1	123,350.2				
Санхүүгийн тайлангийн тодруулгад тоног төхөөрөмжийн эхний үлдэгдэл үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн журналаас 12.8 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	12,846.4			1	12,846.4	1	12,846.4				
Дүн	2	136,196.6			2	136,196.6	2	136,196.6				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Аудитаар нийт 26.3 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 15.5 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 10.8 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Амгалан дулааны станц ТӨХК нь Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд ҮАГ-ын 2021 оны 03 сарын 15-ны өдрийн 84/АО170075 дугаартай төлбөрийн актыг хүчингүй болгуулахаар нэхэмжлэл гаргасан боловч 2021 оны 12 сарын 08-ны өдрийн 128/ШШ20210840 шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон тул 2021 оны 12 сарын 31-ны өдөр Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дах 100900000601 тоот дансанд 84/АО170075 тоот актын төлбөр 10.0 сая төгрөгийг байгууллагын данснаас төлж, нягтлан бодогч Ч.Бямбаагаар төлүүлэхээр авлага үүсгэж бүртгэсэн боловч авлагыг барагдуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу	1	10,000.0			1	10,000.0						

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасантай нийцэхгүй байна.												
Ажиллагсдад олгох хоолны хөнгөлөлтийг ээлжийн ажилтанд гараа тутамд 7,000.00 төгрөг, ээлжийн бус ажилтанд ажлын өдөрт 5,000.00 төгрөгөөр тооцож, цалингийн нэмэгдэл олгодог бөгөөд цайны газартай хоолны тооцоог хийхдээ ажиллагсдаас 5.5 сая төгрөгийн хоолны төлбөр илүү суутган авч, цайны газарт шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн бодитой байх гэсэн зарчимтай нийцэхгүй байна.	1	5,489.4			1	5,489.4						
Тус компани Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д өмнөх онд 2,337.3 сая төгрөгийн өглөгтэй байснаас тайлант жилд 9,217.8 сая төгрөгийн цахилгаан худалдан авч 6,149.2 сая төгрөгийг төлж 5,406.0 сая төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байгаа нь батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулах үр дагавартай байна.	1	-			1	-						
Эрчим хүчний технологийн нүүрс 381.4 мянган тонн худалдан авахаар 3 багц болгон 20,823.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг зарлаж, 2023 оны 5 дугаар сарын 22-ны өдөр нээн өөр оролцогч байхгүй тул Дериватив ХХК-тай 14.0 мянган тонн чулуун нүүрсийг тонн бүрийн үнэ 50.0 мянган төгрөгөөр худалдан авах гэрээ байгуулсан байна. Дериватив ХХК нь техникийн тодорхойлолтын 18.6.1-дэх шаардлага хангаагүй, нүүрс олборлох тусгай зөвшөөрөлгүй, улсын бүртгэлийн гэрчилгээнд геофизикийн суурь судалгаа хийх, зөвлөгөө өгөх, геологийн суурь судалгаа хийх зөвлөгөө өгөх, уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх, Палтформ, Форексийн үйлчилгээ үзүүлэхээр үйл ажиллагааны төрлийг заасан байна. Энэ	1	-			1	-						

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

нь ТБОНӨБАУХАТ хуулийн 34.2-т “Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана” гэж заасантай нийцэхгүй байна.												
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж байгаа ч тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй, компанийн үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгаагүй, дансны төлөвлөгөө нь шинэчилсэн санхүүгийн программтай уялдаагүй байна	1	-					1	-				
Бараа материалын дансанд 9.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө буюу хоосон вагон шилжүүлэх тавцангийн хөдөлгүүр бүртгэлтэй байна.	1	9,000.0					1	9,000.0				
НӨАТ-ын тайланд орлогыг 1.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.1.1-т “бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулсан, экспортод гаргасан, түүнчлэн борлуулсан бол тухай бүрд”, гэсэн заалттай нийцэхгүй байна.	1	1,771.6					1	1771.6				
Дүн	7	26,261.0				4	15,489.4	3	10,771.6			

Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 албан шаардлага хүргүүлэв.

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>								
Хамтын гэрээ, дотоод журамд заасны дагуу зарцуулсан спорт, олон нийтийн арга хэмжээ, тойрон аялал, сургалт, рашаан сувилалын хөнгөлөлт зэрэгт 91.0 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай зөрчилдөж байна.	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		